



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
“МОГОЙН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 06

Бүрхээр

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын тов тогтоох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14⁰⁰ цагт, Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, “Могойн гол” ХК-ийн байранд хийхээр зарласугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэхээр тогтоосугай.

- 2.1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон аудит хийгдсэн санхүүгийн тайланг дүгнэх тухай
- 2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн тайланг дүгнэх, 2024 оны зардлын төсвийг батлах тухай
- 2.3. Компанийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мэдээлэх
- 2.4. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 1 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг 2 дугаар хавсралтаар, саналын хуудасны загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Хурлыг зарлах өдрийг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, дахин мэдээлэх өдрийг 04 дүгээр сарын 04-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 04 дүгээр сарын 08-ны өдрөөр, эцнээ санал өгөх хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээн авах эцсийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрөөр тус тус тасалбар болгон тогтоосугай.

5. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Зохион байгуулах комиссын дарга: Б.Должинсорогдог-ТУЗ-ийн дарга

Гишүүдэд:

Н.Төмөрхуяг -ТУЗ-ийн гишүүн

Б.Батхүү - Компанийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Мөнх-Эрдэнэ -ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

6. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.
Тооллогын Комиссын дарга: Л.Шинэцэцэг- компанийн эдийн засагч
Тооллогын комиссын гишүүдэд: С.Даш- компанийн ажилтан
Т.Бат-Очир- иргэн

7. Компанийн дүрэм болон холбогдох хууль тогтоомжийг хариуцлагатай мөрдөж хурал зохион байгуулахыг комиссын дарга (Б.Должинсорогдог), тооллогын комиссын дарга (Л.Шинэцэцэг) нарт даалгасугай.

ДАРГА



Б.ДОЛЖИНСОРОГДОГ